МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД

Засгийн газрын XIII байр, Чингисийн өргөн чөлөө 11,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14251
Утас: (976-51) 26 31 79, Факс: (976-11) 31 23 15,
Цахим шуудан: info@mrt.gov.mn,
Цахим хуудас: www.mrt.gov.mn

2025.04.07 № 01/1557

танай ____________-ны №______________-т

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА
Б.ЦЭНГЭЛ ТАНАА

Үнэлгээ хийсэн тайланг хүргүүлэхтухай

“Монголын иргэний агаарын тээвэр” /МИАТ/ ТӨХК-ийн захирлын 2024 оны гэрээний биелэлтийг дүгнэхтэй холбогдуулан Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 184 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн өмчит хуулийн этгээдийн захиралтай онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх журам”-ын 3.11-д заасны дагуу салбарын яамнаас өгөх үнэлгээг хийж, тайланг хүргүүлж байна.

“МИАТ” ТӨХК-ийн 2024 оны үйл ажиллагааг Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Сайдын тушаалын биелэлт, Шилэн дансны хөтлөлт, Ил тод байдлын үнэлгээ гэсэн 5 үзүүлэлтээр Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасан аргачлалын дагуу дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр 92,9 хувьтай буюу 23,2 оноогоор үнэлэгдлээ.

Хавсралт 8 хуудастай.

Хувийг “Монголын иргэний агаарын тээвэр” ТӨХК -д.

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
УДИРДЛАГА
САЙД
Б.ДЭЛГЭРСАЙХАН
2025.04.08 17:01